



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

МОНГОЛБАНКНЫ ҮНДЭСНИЙ
ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН
2019 ОНЫ ХЯНАЛТЫН ТАЙЛАН





**ҮНДЭСНИЙ ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН
2019 ОНЫ ХЯНАЛТЫН ТАЙЛАН**

| | |
|--|----------|
| ӨМНӨХ ҮГ | 1 |
| НЭГ. ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ХЯНАЛТЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН | |
| ЗАРЧМУУД..... | 2 |
| <i>Үндэсний төлбөрийн систем гэж юу вэ?.....</i> | <i>2</i> |
| <i>Төлбөрийн системийн эрсдэл</i> | <i>2</i> |
| <i>Төлбөрийн системийн хяналт гэж юу вэ?</i> | <i>3</i> |
| <i>Төлбөрийн системийн хяналтын зарчмууд.....</i> | <i>3</i> |
| ХОЁР. МОНГОЛБАНКНААС ТАВИХ ХЯНАЛТЫН ХАМРАХ ХҮРЭЭ | 5 |
| <i>Их дүнтэй төлбөрийн систем</i> | <i>5</i> |
| <i>Бага дүнтэй төлбөрийн систем</i> | <i>6</i> |
| <i>Картын клирингийн систем.....</i> | <i>6</i> |
| <i>Зөвшөөрлийн тухай</i> | <i>7</i> |
| ГУРАВ. МОНГОЛБАНКНААС ХЯНАЛТЫН ТАЛААР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН | |
| АРГА ХЭМЖЭЭ | 9 |
| <i>Төлбөрийн системийн хяналтын хууль эрх зүйн зохицуулалт</i> | <i>9</i> |
| <i>Төлбөрийн системийн хяналтын үйл ажиллагаа</i> | <i>9</i> |
| 1. Шаардлагатай мэдээлэл цуглуулах | 9 |
| 2. Хяналт тавих..... | 10 |
| 3. Үнэлгээ хийх | 12 |
| 4. Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх | 12 |
| 5. Шаардлагатай өөрчлөлт хийх | 13 |

ӨМНӨХ ҮГ

Монголбанкнаас хэрэгжүүлж буй төлбөрийн системийн хяналттай холбоотой үйл ажиллагааг нийтэд ил тод болгох зорилгоор “Үндэсний төлбөрийн системийн хяналтын жилийн тайлан”-г бэлтгэн гаргалаа.

Энэ тайлан нь төлбөр системийн оператор, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид, дотоодын болон олон улсын зохицуулагч байгууллагууд, хэрэглэгчдэд Монголбанкнаас төлбөрийн системд тавих хяналтын талаарх мэдээллийг хүргэх, түүний ач холбогдолыг таниулах зорилготой юм.

Тайлан дараах 3 бүлэгтэй.

1. Төлбөрийн системийн хяналтын талаарх олон улсын зарчмууд;
2. Монголбанкнаас тавих хяналтын хамрах хүрээ;
3. Монголбанкнаас хяналтын талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ.

НЭГ. ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ХЯНАЛТЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ЗАРЧМУУД

Үндэсний төлбөрийн систем гэж юу вэ?

Төлбөрийн систем гэж төгрөг, валютаар хийгдэх шилжүүлэг болон төлбөрийн даалгаврын боловсруулалт хийх, илгээх, дамжуулах, хүлээн авахтай холбогдох үйлчилгээ, төлбөрийн хэрэгсэл гаргах үйл ажиллагаа, төлбөрийн, клирингийн болон төлбөр тооцооны систем, Монгол Улсын нутаг дэвсгэрт хэсэгчлэн болон бүхэлд нь үйл ажиллагаа эрхэлж байгаа системийн оператор, оролцогч, тэдгээрийн нэрийн өмнөөс төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч гуравдагч этгээд, тэдгээрийн цогц нэгдэл юм¹.

Төлбөр, мөнгөн гуйвуулга, үнэт цаасны клиринг, төлбөр тооцооны системүүд нь нийт эдийн засаг дахь мөнгөний эргэлтийг хурдасгах, ялангуяа санхүүгийн системын хэвийн үйл ажиллагааг хангахад нэн чухал үүрэг

гүйцэтгэдэг. Эдгээр системийн үр ашигтай, хэвийн ажиллагаа нь байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүн, бизнес эрхлэгчдэд санхүүгийн үүргээ биелүүлэх, мөнгөн хөрөнгөө аюулгүй шилжүүлэх боломжийг олгодог.

Төлбөрийн системийн эрсдэл

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 онд батлагдсан “Төлбөрийн системийн хяналтын бодлого”-т төлбөрийн системд зээлийн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын, системийн, хууль эрх зүйн, үйл ажиллагааны, төлбөр тооцооны, бизнесийн эрсдэл үүсч болно гэж тодорхойлсон байна.

Зөв зохион байгуулж, зохистой удирдаж чадсан төлбөрийн систем нь санхүүгийн тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн өсөлтийг дэмжих сайн талтай. Төлбөрийн системийн үр ашигтай, аюулгүй, найдвартай ажиллагаа нь төлбөрийн үйлчилгээний зардлыг бууруулах, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, санхүүгийн зах зээл болон эдийн засгийн бусад үйл ажиллагааны хэвийн байдлыг хангах боломжийг бүрдүүлдэг. Харин төлбөрийн системийн үйл ажиллагааны доголдол нь санхүүгийн зах зээл дээр хүндрэл үүсгэх, ялангуяа зах зээлийн хямралын

үед хямралыг даамжруулах эх үүсвэр болдог. Төлбөрийн системийн үр ашиггүй байдлаас шалтгаалж хэрэглэгчийн зардал өсч, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд саад учирдаг. Илүү өргөн хүрээнд авч үзвэл дээр дурдсан асуудлууд нь санхүүгийн систем болон үндэсний мөнгөн тэмдэгтэд итгэх олон нийтийн итгэлд сөргөөр нөлөөлж болзошгүй юм. Төлбөрийн системийн хэмжээнд гүйлгээний тоо болон дүн хурдацтай өсөхийн хэрээр тухайн системд учирч болзошгүй эрсдэлийн хэмжээ нэмэгдэнэ.

¹ <https://www.legalinfo.mn/law/details/12668>

Өндөр түвшний технологи нэвтрэхтэй зэрэгцэн шинэ дэвшилтэт төлбөрийн хэрэгслүүд болон төлбөр төлөх арга хэлбэр нэмэгдэж, төлбөрийн системийн үйл ажиллагааг нийтэд нь нарийн төвөгтэй, олон талт болгож байна. Мөн сүүлийн жилүүдэд хувийн хэвшлийн зүгээс төлбөрийн үйлчилгээ үзүүлэх нь эрчимтэй нэмэгдэж, банк бус эсвэл

санхүүгийн бус байгууллага тус зах зээлд хүч түрэн орж байна. Энэ хандлага нь тодорхойгүй нөхцөл байдлыг үүсгэж, эрсдэлийг нэмэгдүүлж байгаа учраас төлбөр систем болон клирингийн дэд бүтэц, төлбөрийн зохицуулалтыг бүхэлд нь хамарсан цогц хяналтыг хэрэгжүүлэх шаардлагатай байдаг.

Төлбөрийн системийн хяналт гэж юу вэ?

Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, төлбөрийн хэрэгсэл гаргагч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагааг эрхлэх эрх бүхий этгээд болон операторын зохистой засаглал, удирдлага, үйл ажиллагаа, хэрэглэгчтэй холбогдох харилцаа, систем хоорондын хамаарлыг зохицуулсан журам, дүрэм, шийдвэрийн хэрэгжилтэд нь хяналт тавихыг хэлнэ.

Төлбөрийн системийн хяналтын зорилго нь системийн эрсдэлийг хязгаарлан, хэрэглэгчийн болон эдийн засгийн хэрэгцээг хангаж, найдвартай, үр ашигтай ажиллагааг баталгаажуулахад оршино. Энэ нь урьдчилж тогтоосон стандарт болон хяналтын бодлогод заасан шаардлагын дагуу төлбөрийн системийг үнэлэхээс гадна эдийн засаг дахь төлбөр тооцооны зохицуулалтыг бүхэлд нь бэхжүүлэхэд чиглэсэн маш өргөн үйл ажиллагааг хамардаг. Төлбөрийн системийн хяналтын үүрэг

нь банкны хяналт шалгалтаас ялгаатай ойлголт билээ. Банкны хяналт шалгалт нь тухайн нэг банкны санхүүгийн байдлыг нэг бүрчлэн хянаж, шалгадаг бол төлбөрийн системийн хяналт нь төлбөр тооцоог гүйцэтгэх системийн үйл ажиллагаа, түүний оролцогч болон оператор, төлбөрийн хэрэгслийн хэрэглээг бүхэлд нь хянаж, төлбөрийн системийн найдвартай байдлыг хангуулж, төлбөр тооцоонд итгэх итгэл, санхүүгийн тогтвортой байдлыг дэмжихэд чиглэдэг.

Төлбөрийн системийн хяналтын зарчмууд

Төв банкны төлбөрийн системийн хяналтын чиг үүрэг нь Олон улсын төлбөр тооцооны банкны Төлбөрийн болон зах зээлийн дэд бүтцийн хороо (ТЗЗДБХ)-оос боловсруулан гаргасан олон улсад нийтлэг мөрдөх тодорхой зарчмуудад тулгуурладаг. Тус

хорооноос 2005 онд гаргасан “Төв банкны хяналтын тайлан”-д² дотоодын болон олон улсын хэмжээнд төлбөр тооцооны системүүдэд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх үндсэн 5 зарчмыг тодорхойлсон.

² <https://www.bis.org/cpmi/publ/d68.pdf>

ТЗЗДБХ-оос тодорхойлсон үндсэн 5 зарчим:

1. Төв банк нь өөрийн хяналтын бодлогоо олон нийтэд мэдээлэх ёстой ба ингэхдээ систем бүрт тавигдах бодлогын шаардлага эсвэл стандартууд мөн аль системд хамаарахыг тогтоох шалгуурууд зэргийг тодорхойлно.

1.2. Төв банк нь төлбөрийн системүүдэд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн холбогдох стандартыг мөрдүүлэх ёстой.

3. Төв банк нь хяналтын үүрэг хариуцлагаа үр дүнтэй хэрэгжүүлэх бүрэн эрх, чадавхтай байх ёстой.

4. Төв банкны ажиллуулдаг системүүд, бусад төлбөрийн системүүдэд хяналтын стандартуудыг тогтмол мөрдүүлэх ёстой.

1.5. Төлбөрийн системүүдийн аюулгүй, үр ашигтай байдлыг дэмжихийн тулд төв банк нь бусад төв банкууд болон эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах ёстой.

Дээр дурдсан “Төв банкны хяналтын тайлан”-аас гадна ТЗЗДБХ болон Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага (ҮЦХОУБ)-аас хамтран гаргасан “Санхүүгийн зах зээлийн дэд

бүтэц (СЗЗДБ)-ийн зарчим”-д³ СЗЗДБ-ийн хяналт, зохицуулалт, шалгалттай холбоотойгоор эрх бүхий байгууллагын хүлээх 5 үүрэг хариуцлагыг тодорхойлсон байдаг.

³ <http://www.bis.org/cpmi/publ/d101a.pdf>

ХОЁР. МОНГОЛБАНКНААС ТАВИХ ХЯНАЛТЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд заасны дагуу Монголбанк нь үндэсний төлбөрийн систем (ҮТС)-ийн найдвартай, үр ашигтай байдлыг хангах бүрэн эрхийн хүрээнд төлбөрийн системийн хяналтын хамрах хүрээг тодорхойлно. Монголбанк нь дараах төлбөрийн систем болон төлбөрийн хэрэгсэлд хяналт тавих үүргийг хүлээдэг.

Их дүнтэй төлбөрийн систем

Монголбанкны Бодлого зохицуулалт, үйл ажиллагааны хэлтэс (БЗҮАХ)-ийн хариуцан ажиллуулж буй их дүнтэй төлбөр систем буюу Банксүлжээ (RTGS - Real Time Gross Settlement) систем нь Монгол Улсын үндэсний төлбөрийн системийн суурь юм. Энэ системд банкууд, банкны эрх хүлээн авагч 2, Хөгжлийн банк, Сангийн яамны Төрийн сангийн газар, Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК холбогдсон.

Банксүлжээ систем нь төлбөрийн системийн оролцогч хооронд хийгдэж буй их дүнтэй төлбөр нэг бүрийг бодит цагийн горимоор Монголбанканд байршиж буй харилцах дансаар дамжуулан гүйцэтгэдэг.

Түүнчлэн Үндэсний цахим гүйлгээний төвийн (ҮЦГТ) хариуцан ажиллуулж буй системээр тухайн өдөрт дамжсан оролцогч хоорондын бага дүнтэй болон картын төлбөрий үр дүнгийн тооцооллын хаалтын гүйлгээг дараагийн ажлын өдөрт нь гүйцэтгэж байна. Бодит цагийн горимд ажилладаг их дүнтэй төлбөрийн системийг нэн чухал систем гэж тооцон, Төв банк эзэмшиж, үйл ажиллагааг нь удирдан зохион

байгуулдаг сайн туршлагыг олон улсад нийтлэг баримтладаг.

Банксүлжээ системийн үйл ажиллагааг Монголбанкны Ерөнхийлөгчийн (МБЕ) 2018 оны А-88 тоот тушаалаар батлагдсан “Их дүнтэй төлбөрийн системийн журам”-аар⁴ зохицуулж байна.

Банксүлжээ системийн програм хангамж нь 2 дугаар үеийн хувилбараар (2nd generation RTGS) ажиллаж байна. Банксүлжээ системд дансны нэгдсэн дугаарлалтыг нэвтрүүлсэн бөгөөд ингэснээр олон улсын төлбөр тооцоо гүйцэтгэхэд илүү хялбар болох, банк хоорондын төлбөр тооцоонд одоогийн ашиглаж байгаа дансдын давхцал арилах, банкны ажилтан дансны дугаарыг шивэх явцдаа тухайн данс зөв эсэхийг шалгах зэрэг боломжтой. болсон. Цаашид Банксүлжээ системд буцаалтын гүйлгээ хийх, оролцогч хоорондын валютын гүйлгээ хийх, оролцогчийн дансанд барилт хийх зэрэг боломж бий болно. Тус систем санхүүгийн байгууллага хоорондын цахим мэдээ солилцох олон улсын ISO20022 стандартадын дагуу явагдаж байна.

4

<https://www.mongolbank.mn/documents/regulation/paymentsystem/ihduntei.pdf>

Бага дүнтэй төлбөрийн систем

Монголбанкны ҮЦГТ-ийн хариуцан ажиллуулдаг бага дүнтэй төлбөрийн систем нь оролцогч хоорондын бага дүнтэй гүйлгээг 7 хоногийн 24 цагаар илгээсэн даруйд нь хүлээн авагчийн дансанд нь тусгаж байна. МБЕ-ийн 2018 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн тушаалаар бага дүнтэй гүйлгээний мөнгөн дүнгийн дээд хязгаарыг 3 сая төгрөг болгож нэмэгдүүлсэн. Тус системийн оролцогчид нь банкууд, Хөгжлийн банк, Сангийн яамны Төрийн сангийн газар, Арилжааны төлбөр тооцоо ТӨХХК, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ТӨХХК байна.

Төлбөрийн системийн шинэчлэл төслийн хүрээнд бага дүнтэй төлбөрийн системийн програм хангамжийг шинэчлэн АСН+ буюу автомат клиринг хаус системийг нэврүүлэх ажил хийгдэж, 2019 оны 8 дугаар сарын 15-ны өдөр бүрэн нэвтрүүлсэн.

АСН+ системийг нэвтрүүлнээр кредит шилжүүлэг, гүйлгээний бодит цагийн

горимыг хадгалахаас гадна харилцагчийн хүсэлтээр төлбөрийн нэхэмжлэхэд суурилсан дебит гүйлгээг илгээх, ижил төрөл болон зориулалт бүхий гүйлгээг багцлан илгээх боломж бий болсон. Энэ нь иргэд үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай урьдчилан гэрээ байгуулсны үндсэн дээр байнгын давтамжтай аливаа хуваарьт төлбөрийг цаг хугацаанд нь, хоцрогдолгүйгээр төлөх нөхцлийг бүрдүүлсэн. Тус системд томоохон аж ахуйн нэгж байгууллагууд шууд холбогдох боломжтой юм.

Энэ системийн үйл ажиллагааг МБЕ-ийн 2019 оны А-218 тоот тушаалаар батлагдсан “Автомат клиринг хаус системийн дүрэм”-ээр⁵ зохицуулдаг. Автомат клиринг хаус системийг олон улсад жижиглэнгийн төлбөрүүдэд зориулсан системийн нэг төрөл гэж үздэг.

Картын клирингийн систем

Оролцогч хоорондын картын клирингийн систем нь АТМ-аас бэлэн мөнгө авах, шилжүүлэг хийх, ПОС төхөөрөмж дээр бараа үйлчилгээний төлбөр төлөх, цахим худалдан авалт хийх зэрэг төлбөрийн картын гүйлгээг боловсруулах жижиглэнгийн төлбөрүүдэд зориулсан систем юм. Монгол Улсад ҮЦГТ болон Худалдаа хөгжлийн банк (ХХБ) ны хариуцан

ажиллуулж буй картын клирингийн хоёр систем байна. Энэ 2 систем нь тус бүрдээ үйл ажиллагаа явуулдаг боловч техник технологийн түвшинд харилцан холбогдсон байдаг тул тухайн системүүдийн оролцогч хооронд төлбөр гүйцэтгэх боломж бүрэн хангагдсан. ҮЦГТ-ийн систем нь тухайн өдөрт төлбөрийн системийн оролцогч хооронд дамжсан гүйлгээний үр дүнгийн

5

<https://www.mongolbank.mn/documents/regulation/paymentsystem/2019/ACH%20%D1%81%D0%B>

<https://www.mongolbank.mn/documents/regulation/paymentsystem/2019/ACH%20%D1%81%D0%B8%D0%B9%D0%BD%20%D0%B4%D2%AF%D1%80%D1%8D%D0%BC.pdf>

тооцооллын хаалтын дүнг Банксүлжээ системд дамжуулснаар төлбөр тооцоо хийгддэг.

Тус картын клирингийн системийн оролцогчид нь ХХБ, ХААН банк, Голомт банк, Хас банк, Төрийн банк, Чингис хаан банк, Хай пэймэнт ХХК байна.

Картын клирингийн системийн үйл ажиллагааг системийн өөрийн дүрэм, МБЕ-ийн 2019 оны А-92 тоот тушаалаар батлагдсан “Төлбөрийн картын журам”⁶, МБЕ-ийн 2018 оны А-263 тоот тушаалаар батлагдсан “Клирингийн системийн оператор болон төлбөр тооцооны төлөөлөгчийн үйл ажиллагааны журам”⁷-аар тус тус зохицуулдаг.

Зөвшөөрлийн тухай

Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд заасан үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийн хүрээнд хуультай нийцүүлэн гаргасан “Клирингийн системийн оператор болон төлбөр тооцооны төлөөлөгчийн үйл ажиллагааны журам”, “Төлбөрийн картын журам”, “Цахим мөнгөний журам”-ын дагуу Монголбанк 2019 онд үйл ажиллагааны 22 зөвшөөрлийн хүсэлтийг хүлээн авсан. Зөвшөөрөл хүсч ирүүсэн материалыг судалж үзэн зөвшөөрлийг дараахь байдлаар сунгаж, шинээр олгож ажиллаа.

Сунгасан:

6

https://www.mongolbank.mn/documents/regulation/paymentsystem/payment_card.pdf

ХХБ-ны картын клирингийн систем нь Монголбанкнаас “Клирингийн системийн оператор болон төлбөр тооцооны төлөөлөгчийн үйл ажиллагааны журам”⁸-д заасны дагуу үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг авсан. ХХБ-ны картын клирингийн системийн оролцогчид нь Ариг банк, Улаанбаатар хотын банк, Капитрон банк, Үндэсний хөрөнгө оруулалтын банк, Тээвэр хөгжлийн банк, Богд банк, Кредит банк байна. Тус систем нь өөрийн сүлжээний оролцогчийн картын гүйлгээг дамжуулж, үр дүнгийн тооцооллыг хийдэг. Энэхүү үйл ажиллагааг өөрийн системийн дүрэмээр зохицуулдаг.

- Төлбөрийн карт гаргах, хүлээн авах зөвшөөрлийг 8 банкинд сунгасан.

Шинээр олгосон:

- Төлбөрийн карт гаргах, хүлээн авах нэмэлт зөвшөөрөл 1 банкинд
- Төлбөрийн карт гаргах, хүлээн авах зөвшөөрлийг 1 банкинд
- Төлбөрийн карт гаргах, хүлээн авах зөвшөөрлийг 1 байгууллагад
- Төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх зөвшөөрлийг 1 банкинд

7

https://www.mongolbank.mn/documents/regulation/paymentsystem/2018/20181030_A263.pdf

9

https://www.mongolbank.mn/documents/regulation/paymentsystem/2016/20160928_A265.pdf

- Төлбөрийн картын процессорын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 1 банк, 3 байгууллагад тус тус олгосон байна.

Харин цахим мөнгө гаргах хүсэлт гаргасан 2 байгууллага, систем ажиллуулах зөвшөөрөл хүссэн 1 байгууллагад хууль, журмын шаардлага

хангаагүй тул холбогдох зөвшөөрөл олгохоос татгалзсан шийдвэр гарсан.

Монголбанкнаас олгосон төлбөрийн хэрэгсэл гаргах үйл ажиллагааны зөвшөөрлийн дэлгэрэнгүйг Хавсралт 1-д, бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн дэлгэрэнгүйг Хавсралт 2-д үзүүлээ.

ГУРАВ. МОНГОЛБАНКНААС ХЯНАЛТЫН ТАЛААР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

Монголбанкнаас хэрэгжүүлж буй төлбөрийн системийн хяналтын үүрэг нь төлбөр тооцооны системүүдийг болон төлбөрийн зохицуулалтыг үүсэж болзошгүй эрсдэлээс хангалттай хэмжээнд хамгаалж байгааг, түүнчлэн системийн бүтэц, тухайн системийг Төв банк эсвэл хувийн хэвшил хариуцан ажиллуулж байгаа эсэхээс үл хамааран үр ашигтай ажиллаж байгааг баталгаажуулах явдал юм.

Төлбөрийн системийн хяналтын хууль эрх зүйн зохицуулалт

Олон улсад нийтлэг мөрдөгдөх зарчмуудад Төв банкныг хяналтын зорилгод нийцүүлэн хүлээсэн эрх, үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлэх хууль ёсны онцгой эрхтэй, хүчин чадалтай байхыг шаарддаг. Төв банк (Монголбанк)-ны тухай хуулинд Монголбанк нь үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, зохицуулах, хяналт тавихаар заасан. Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд Монголбанк нь ҮТС-ийг бүхэлд нь болон бүрэлдэхүүн хэсгүүдийг зохицуулах, хяналт тавих үүргийг Монголбанканд хүлээлгэсэн.

Монголбанкнаас төлбөрийн системийн хяналтыг хэрэгжүүлэхдээ МБЕ-ийн 2016 оны А-265 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн системийн хяналтын бодлого”-ыг⁹ удирдлага болгодог, Хяналт зохицуулалтын хэлтэс (ХЗХ)-ийн хянан шалгагчид үйл ажиллагаандаа МБЕ-ийн 2015 оны А-76 тушаалаар батлагдсан “Төлбөрийн системийн оролцогчдын үйл ажиллагаанд газар дээр нь шалгалт хийх журам”-ыг¹⁰ мөрдөж ажилладаг.

Төлбөрийн системийн хяналтын үйл ажиллагаа

Монголбанк төлбөрийн системийн хяналтыг хэрэгжүүлэхдээ дараах үндсэн 5 үйл ажиллагааг явуулж байна.

1. Шаардлагатай мэдээлэл цуглуулах

Төлбөр тооцооны газар (ТТГ)-ын ХЗХ нь Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн дагуу төлбөрийн системд хяналт тавих чиг үүрэгтэй ажиллаж, төлбөрийн системийн оролцогчдоос

шаардлагатай мэдээллийг цаг тухайд нь гаргуулан авдаг. Холбогдох журмуудад үндэслэн оролцогчид гүйлгээний тоон мэдээллийг Монголбанкинд тогтмол ирүүлдэг. Тоон мэдээллийг нэгтгэн улирал бүр төлбөрийн системийн тайланг бэлтгэж, Монголбанкны цахим

9

https://www.mongolbank.mn/documents/regulation/paymentsystem/2016/20160928_A265.pdf

10

https://www.mongolbank.mn/documents/regulation/paymentsystem/2015/20150428_A76.pdf

хуудсанд¹¹ байршуулж нийтэд ил тод болгодог. Хяналтанд хамрагдаж байгаа төлбөрийн системүүд 7 хоног бүр тухайн системээр дамжсан амжилттай болон амжилтгүй гүйлгээний мэдээлэл, тасралтгүй найдвартай ажиллагааны үзүүлэлт зэргийг багтаасан үйл ажиллагааны тайлан гаргаж, ХЗХ-т ирүүлж байна. Энэ үйл ажиллагааны тайланг сар бүр нэгтгэн, Монголбанкны удирдлагад танилцуулж, мэдээллээр хангаж байна.

2. Хяналт тавих

ХЗХ нь оператор болон оролцогчийн эрх зүйн баримт, мэдээлэл, статистик үзүүлэлтүүдийг тогтмол, тодорхой давтамжтайгаар цуглуулж, дүрэм, журамд нийцэж байгаа эсэхэд хяналт тавин ажиллаж байна. Газар дээр хийсэн шалгалтын үр дүнг системийн найдвартай, үр ашигтай байдлын үнэлгээнд ашигладаг.

Төлбөрийн системийн оролцогчдийг хамруулсан газар дээрх шалгалтуудыг 2019 онд дараахь байдлаар хийж гүйцэтгэсэн :

- Төв банкны хариуцсан төлбөрийн системийн операторын үйл ажиллагааны шалгалт /Банксүлжээ систем, ҮЦГТ-ийн бага болон картын клирингийн систем/
- Бусад төлбөрийн системийн операторын үйл ажиллагааны шалгалт /ХХБ-ны картын клирингийн систем/,
- Төлбөрийн системийн оролцогч банкуудын иж бүрэн шалгалт,

- Төлбөрийн системийн тайлантай холбоотой банкуудын хэсэгчилсэн шалгалт,
- Цахим мөнгөний үйл ажиллагааны иж бүрэн шалгалтыг тус тус хийж гүйцэтгэсэн.

Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг тухайн оролцогчид тухай бүрт мэдэгдэж, залруулах талаар хянан шалгагч нар өөрийн бүрэн эрхийн хүрээнд арга хэмжээ авч ажилласан.

Түүнчлэн банкуудаас системийн хэмжээний тайланг гаргуулан авч, мониторинг хийдэг бөгөөд тоон мэдээнд үндэслэн хяналт шинжилгээ хийж байна. Улирал тутам гаргаж буй төлбөрийн системийн тайлан, мэдээг Монголбанкны цахим хаягаас¹² авах боломжтой.

Их дүнтэй төлбөрийн системээр дамжсан гүйлгээний тоо ба дүнг График 1-т, бага дүнтэй төлбөрийн систем, картын клирингийн системээр дамжсан гүйлгээний тоо ба дүнг 2018-2019 онд улирал бүрээр График 2-т харуулав.

График 1-ээс үзэхэд 2018 оны 4 дүгээр улирлаас их дүнтэй гүйлгээний тоо огцом буурсан нь бага дүнтэй гүйлгээний хязгаарыг 1 саяаас 3 сая төгрөг болгож шинэчилсэнтэй холбоотой ба энэ нь График 2-ын бага дүнтэй гүйлгээний дүнгийн огцом өсөлтийг ч мөн тайлбарлана. Харин энэхүү өөрчлөлт нь их дүнтэй гүйлгээний дүн болон бага дүнтэй гүйлгээний тоонд нөлөө бага үзүүлсэн. График 2-оос үзэхэд картын нэгдсэн сүлжээний гүйлгээний тоо, дүн өссөн үзүүлэлтэй байна.

¹¹ <https://mongolbank.mn/liststatistic.aspx?id=15>

¹² <https://mongolbank.mn/liststatistic.aspx?id=15>

График 1






График 2



Хяналт зохицуулалтын хэлтэс нь төлбөрийн системийн оператор болон оролцогчдын тасралтгүй найдвартай ажиллагаанд тогтмол хяналт тавин ажиллаж байна. 2019 оны 11 дүгээр сарын байдлаар Банксүлжээ системд нийт 282 минутын тасралт үүссэн. Эдгээр тасралтууд нь техник, програм

хангамж, өгөгдлийн сангийн алдаа зэрэг үйл ажиллагааны эрсдэлээс үүссэн байна. Бага дүнтэй төлбөрийн систем, ҮЦГТ-ийн картын клирингийн систем, ХХБ-ны картын клирингийн системүүд нь 2019 онд тасралтгүй найдвартай ажилласан. Системийн тасралтгүй байдлыг График 3-аас үзнэ үү.

График 3



3. Үнэлгээ хийх

Санхүүгийн зах зээлийн дэд бүтэц (СЗЗДБ)-ийг үнэлэх “Үнэлгээний аргачлал”-ыг МБЕ-ийн 2015 оны А-98 тоот тушаалаар баталсан¹³ бөгөөд уг аргачлалын дагуу жил бүр системийн хувьд нэн чухал төлбөрийн системд үнэлгээ хийдэг. Энэ үнэлгээг хийснээр төлбөрийн системд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлон, түүнийг үнэлэх, бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломж бүрдэж байна.

Монголбанк нь тухайн системээр боловсруулж буй гүйлгээний дундаж дүн, гүйлгээний төрөл, хэрэглэгчийн тоог харгалзан үзсэний үндсэн дээр төлбөрийн системийг системийн хувьд нэн чухал эсэхийг тодорхойлдог. Одоогийн байдлаар энэ шалгуур үзүүлэлтийн дагуу их дүнтэй төлбөрийн Банксүлжээ системийг системийн хувьд нэн чухал гэж үзэж байна. Их дүнтэй гүйлгээний дундаж дүн 2019 онд 200,1 сая төгрөг байна.

"СЗЗДБ-ийн зарчмууд"-д дурдсанаар оролцогчид болон холбогдох эрх бүхий байгууллагууд нь олон нийтийг шаардлагатай мэдээллээр хангах үүрэгтэй байдаг. Тухайн улс орны хууль эрх зүйн орчинд нийцүүлэн холбогдох эрх бүхий байгууллагууд нь зарчмуудын хэрэгжилт болон үүрэг хариуцлагын биелэлтийг хангах шаардлагатай. Мөн удирдлагын үүрэг хариуцлагын үнэлгээний гол зорилго нь эрх бүхий байгууллагууд дэд бүтцийн хяналт шалгалт, зохицуулалттай холбоотой үүрэг хариуцлагаа биелүүлж буй эсэх,

биелэлтийн түвшинг ахиулах, түүнийг дэмжихэд оршино гэжээ.

ОУТТБ-аас гаргасан СЗЗДБ-ийн 24 зарчим, таван үүрэг хариуцлагын хэрэгжилт их дүнтэй төлбөрийн системийн түвшинд хэрхэн хангагдаж байгааг тодорхойлж, хэрэгжилтийн түвшинг ахиулж, тогтмол хангуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор 2019 онд Банксүлжээ системийн үнэлгээг хийсэн. Үнэлгээний үр дүнгээс харахад дэд бүтцийн 24 зарчмын 13 зарчим хэрэгжсэн, 3 зарчим ерөнхийдөө хэрэгжсэн, 1 зарчим хэсэгчлэн хэрэгжсэн, 7 зарчим хамааралгүй байна. Таван үүрэг хариуцлага 2019 оны үнэлгээгээр бүгд хэрэгжсэн байна. Хэрэгжилтийн түвшинг ахиулах шаардлагатай зарчмуудын хувьд анхаарвал зохих асуудлыг шийдвэрлэх талаар системийн операторт зөвлөмж өгсөн.

Түүнчлэн “Төлбөрийн системийн хяналтын бодлого”-д заасны дагуу Монголбанкны хариуцан ажиллуулж буй Төв банкны үнэт цаасны системд хоёр дахь удаа үнэлгээ хийсэн. Үнэлгээний үр дүнгээс харахад дэд бүтцийн 24 зарчмын 12 зарчим бүрэн хэрэгжсэн, 2 зарчим ерөнхийдөө хэрэгжсэн, 1 зарчим хэсэгчлэн хэрэгжсэн, 9 зарчим хамааралгүй байна.

4. Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх

Төлбөр тооцооны газрын Хяналт зохицуулалтын хэлтэс санхүүгийн тогтвортой байдлыг хангахын тулд төлбөрийн системийн эрсдэлийг

13

<https://mongolbank.mn/documents/regulation/paymentsystem/2015/20150706.pdf>

тодорхойлж, үнэлж, бууруулах арга хэмжээ авч байх шаардлагатай. Энэ нь санхүүгийн зах зээл, цаашлаад эдийн засгийг бүхэлд нь хамарч болох үр дагавартай учраас системийн эрсдэлийг төлбөрийн системийн хяналтын үндсэн асуудал болгон тавьдаг. Иймээс хяналтын тогтолцоог сайтар зохион байгуулснаар төлбөрийн системийн эрсдэлийг бууруулах ач холбогдолтой юм.

5. Шаардлагатай өөрчлөлт хийх

Төлбөрийн системийн операторын үйл ажиллагааны шалгалт, Төлбөрийн системийн оролцогч банкуудын иж бүрэн шалгалт, Цахим мөнгөний үйл ажиллагааны иж бүрэн шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах

талаар үүрэг даалгаврыг албан бичгээр хүргүүлж, банкуудаас үүрэг даалгаврын биелэлтийг хүлээн авсан.

Төлбөрийн системийн тайлантай холбоотой банкуудад хэсэгчилсэн шалгалт хийж, цаашид хийх шаардлагатай өөрчлөлтүүдийг тусгаж сайжруулсны дагуу “Төлбөрийн системийн тайлан гаргах заавар”¹⁴-ыг шинээр боловсруулж, МБЕ-ийн 2019 оны А-160 тоот тушаалаар батлуулсан. Банкслжээ системийн 2019 оны үнэлгээ, Төв банкны үнэт цаасны системийн үнэлгээний үр дүнг үндэслэн эдгээр системийн найдвартай, үр ашигтай байдлын түвшинг хангаж байгаа эсэх тухай дүгнэлт гаргаж, тухайн системүүдэд шаардлагатай өөрчлөлтийг хийхэд шаардлагатай арга хэмжээ авахуулахаар ажиллаж байна.

ТӨЛБӨРИЙН ХЭРЭГСЭЛ - ТӨЛБӨРИЙН КАРТ ГАРГАГЧ, ХҮЛЭЭН АВАХ

| № | Зөвшөөрөл эзэмшигч хуулийн ЭТГЭЭД | Карт гаргах зөвшөөрөл | Карт хүлээн авах зөвшөөрөл | Анх зөвшөөрөл олгосон өдөр | Зөвшөөрөл дуусах өдөр |
|---|--|--|--|-------------------------------|--------------------------|
| 1 | Худалдаа хөгжлийн банк http://www.tdbm.mn/mn/ | ₮ карт, Visa, Mastercard, UnionPay | ₮ карт, Visa, Mastercard, UnionPay, JCB, Diners Club, Discover | 2010.06.25 | Хугацаагүй |
| 2 | Хаан банк https://www.khanbank.com/ | ₮ карт, Visa, Mastercard, UnionPay | ₮ карт, Visa, Mastercard, UnionPay, JCB | 2011.12.30 | Хугацаагүй |
| 3 | Голомт банк http://www.golomtbank.com/ | ₮ карт, AMEX, Visa, Mastercard, UnionPay | ₮ карт, AMEX, Visa, Mastercard, UnionPay | 2009.12.31 | Хугацаагүй |
| 4 | Ариг банк https://www.arigbank.mn | ₮ карт, Visa | ₮ карт, Visa, UnionPay, JCB, | 2012.12.05 | Хугацаагүй |
| 5 | Улаанбаатар хотын банк http://www.ubcbank.mn | ₮ карт, Visa | ₮ карт, Visa, UnionPay, JCB | 2010.12.29 | Хугацаагүй |
| 6 | Үндэсний хөрөнгө оруулалтын банк http://www.nibank.mn | ₮ карт, Visa | ₮ карт, UnionPay, Visa, JCB | 2013.01.08 | Хугацаагүй |

| | | | | | |
|----|--|--------------------------------------|--------------------------------------|------------|------------|
| 7 | Капитрон банк http://www.capitronbank.mn/ | ₮ карт, Visa, UnionPay | ₮ карт, Visa, UnionPay JCB | 2012.09.26 | Хугацаагүй |
| 8 | Хас банк http://www.xacbank.mn/ | ₮ карт, Visa, UnionPay | ₮ карт, Visa, UnionPay, JCB | 2011.07.29 | 2020.08.01 |
| 9 | Чингис хаан банк http://www.ckbank.mn/ | ₮ карт, Visa | ₮ карт, Visa, UnionPay | 2013.04.30 | Хугацаагүй |
| 10 | Төрийн банк https://www.statebank.mn/w/mn/ | ₮ карт, Visa, UnionPay, JCB | ₮ карт, Visa, UnionPay, JCB | 2014.03.18 | 2020.03.18 |
| 11 | Богд банк http://www.bogdbank.com/ | ₮ карт, Visa, UnionPay, | ₮ карт, Visa, UnionPay | 2016.09.21 | Хугацаагүй |
| 12 | Тээвэр хөгжлийн банк http://www.transbank.mn/ | ₮ карт, UnionPay | ₮ карт, UnionPay | 2017.11.17 | 2020.11.17 |
| 13 | Кредит банк http://www.creditbank.mn/ | ₮ карт, | ₮ карт, UnionPay | 2019.04.24 | 2023.04.24 |
| 14 | Хай пэймэнт солиушнс ХХК http://www.hipay.mn/ | | ₮ карт, UnionPay, JCB, | 2019.10.24 | 2023.10.24 |

ТӨЛБӨРИЙН ХЭРЭГСЭЛ - ЦАХИМ МӨНГӨ

| № | Зөвшөөрөл эзэмшигчийн нэр | Зөвшөөрлийн нэр | Зөвшөөрөл олгосон өдөр | Зөвшөөрөл дуусах өдөр |
|---|--|--|------------------------|-----------------------|
| 1 | Мобифинанс ББСБ ХХК http://mobifinance.mn/ | Цахим мөнгө гаргах төлбөрийн үйлчилгээ үзүүлэх | 2018.09.27 | 2022.09.27 |

ТӨЛБӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХТЭЙ ХАМААРАЛ БҮХИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ

| № | Зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд | Зөвшөөрлийн нэр | Зөвшөөрөл олгосон өдөр | Зөвшөөрөл дуусах өдөр |
|---|---|---|------------------------|-----------------------|
| 1 | Гурван зуун жар финанс ББСБ ХХК | Төлбөрийн картын процессорын үйл ажиллагаа эрхлэх | 2019.04.26 | 2023.04.26 |
| 2 | Худалдаа хөгжлийн банк http://www.tdbm.mn/mn/ | Төлбөрийн картын процессорын үйл ажиллагаа эрхлэх | 2019.10.22 | 2023.10.22 |
| 3 | Дата бэйнк ХХК | Төлбөрийн картын процессорын үйл ажиллагаа эрхлэх | 2019.10.24 | 2023.10.24 |
| 4 | ККТТ ХХК | Төлбөрийн картын процессорын үйл ажиллагаа эрхлэх | 2019.11.29 | 2023.11.29 |

ТӨЛБӨР ТООЦООНЫ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ БАНК

| № | Зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд | Зөвшөөрлийн нэр | Зөвшөөрөл олгосон өдөр | Зөвшөөрөл дуусах өдөр |
|---|---|--|------------------------|-----------------------|
| 1 | Хас банк http://www.xacbank.mn/ | Төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх | 2019.10.07 | 2023.10.07 |

СИСТЕМ АЖИЛЛУУЛАХ

| № | Зөвшөөрөл эзэмшигчийн нэр | Зөвшөөрлийн нэр | Зөвшөөрөл олгосон өдөр | Зөвшөөрөл дуусах өдөр |
|---|---|--|------------------------|-----------------------|
| 1 | Худалдаа хөгжлийн банк http://www.tdbm.mn/mn/ | Картын клирингийн систем ажиллуулах (гишүүдийн хооронд) | 2019.10.22 | 2023.10.22 |